

ДЭД ДАРГА

БАТЛАВ

С.ДАВААСҮРЭН

ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

2017.03.13

№ 2017/01

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны нэгдсэн төлөвлөгөөнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр зарлагдсан хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Нийгмийн даатгалын тухай” хуулиуд, Засгийн газрын 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг шалгаж эрсдлийн түвшинг тогтоон, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллахад оршино.

Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхдээ Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2013 оны 96 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баримтлан ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны нэгдсэн төлөвлөгөөнд зарлагдсан Улаанбаатар хотод хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдана.

Зөвлөн туслах үйлчилгээг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүн, хамрагдах асуудлууд

Зөвлөн туслах үйлчилгээг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын хэлтсийн, дүүргүүд дэх мэргэжлийн хяналтын хэлтсийн хөдөлмөрийн хяналтын, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын, нийгмийн хамгааллын хяналтын улсын / ахлах/ байцаагчид хийж гүйцэтгэнэ.

Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхдээ “4.6 Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”, “4.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”,


“4.1.1 Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас, “4.2 Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар тус тус эрсдлийг үнэлж дүгнэн байгууллагын “Шилэн хяналт”-ын цахим мэдээллийн санд бүртгэнэ.

Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх явцдаа халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын стандарт MNS5216:2016 /ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга/-г хангаагүй тохиолдол илэрвэл холбогдох хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид мэдэгдэнэ.


Дөрөв. Дүн танилцуулах

Дүнг тухайн байгууллагын удирдлагад танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллах талаар улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмжийг өгч ажиллана.


ТАНИЛЦСАН:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ТУСГАЙ ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  И.БАТТӨГС

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН АХЛАХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Д.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ 

М.УУГАНБААТАР

